

# ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН МЭДЭЭЛЭЛ


/2015 оны 4 сарын 01-ны өдрийн байдлаар/

## МАХНЫ ҮНЭ


2015 оны 04 сарын 01-ны өдрийн байдлаар Баруун сайхан, Зүүн сайхан, Хан-уул, худалдааны төвд байрлалтай мах, ногооны захын ханшаар хонины 1 кг мах дунджаар 7000 төгрөгөөр, ямааны мах 6500, адууны мах 6833.3 төгрөгөөр тус тус худалдаалагдаж байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хонины махны үнэ 500 төгрөгөөр, адууны махны үнэ 333 төгрөгөөр тус тус буурч, ямааны махны үнэ тогтвортой байна. Харин өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад хонь, ямааны махны үнэ тогтвортой байна. Нөөцийн махны хувьд Даланзадгад суманд 5 цэгт борлуулагдаж буй бөгөөд үхрийн мах дунджаар 6600 төгрөг, хонины мах дунджаар 5600 төгрөг, ямааны мах дунджаар 4600 төгрөгөөр тус тус худалдаалагдаж байна.

Зураг1. Махны үнэ 2015 оны 3-4 сар


Хонины махны үнэ, 1 кг, төгрөгөөр



Адууны махны үнэ, 1 кг, төгрөгөөр




Ямааны махны үнэ, 1 кг, төгрөгөөр



## ГУРИЛ, БУДАА, СҮҮ, ЭЛСЭН ЧИХРИЙН ҮНЭ

2015 оны 4-р сарын 01-ны өдрийн байдлаар малын шингэн сүү худалдаанд зарагдахгүй байна. Харин цагаан будааны үнэ дунджаар 2060 төгрөг, элсэн чихрийн үнэ дунджаар 2000 төгрөг, алтан тариа 1-р гурил 1100 төгрөгөөр худалдаалагдаж байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад алтан тариан гурил 11.9 хувиар, цагаан будааны үнэ 3.0 хувиар өсч, элсэн чихрийн үнэ өөрчлөлтгүй байна. Харин өмнөх 7 хоногийнхтой харьцуулахад тогтвортой байна.


Зураг 2. Цагаан будаа, элсэн чихэр, гурилын үнэ, 2015 оны 3-4 сар, төгрөгөөр



## АВТОБЕНЗИН, ДИЗЕЛИЙН ТҮЛШНИЙ ҮНЭ

2015 оны 04-р сарын 01-ны өдрийн байдлаар Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулж байгаа Шатахуун түгээх газруудын мэдээгээр бензин А-80 дунджаар 1650 төгрөг, бензин АИ-92 дунджаар 1890 төгрөг, дизелийн түлш дунджаар 1910 төгрөгийн үнэтэй худалдаалагдаж байгаа нь өмнөх долоо хоногийнхтой харьцуулахад тогтвортой байна.


Зураг 3. Авто бензин, дизелийн түлшний үнэ, 2015 он 3-4 сар, төгрөгөөр



## ЯМААНЫ НООЛУУРЫН ҮНЭ

2015 оны 04-р сарын 01-ны өдрийн байдлаар Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулж буй түүхий эдийн захад ямааны ноолуур дунджаар 35000 төгрөгийн үнэтэй худалдаалагдаж байгаа нь өмнөх долоо хоногийнхтой харьцуулахад 31.0 хувиар буурсан байна.

Зураг 4. Ямааны ноолуурын үнэ, 2015 он 3-4 сар, төгрөгөөр



Өмнөговь аймгийн Статистикийн хэлтэс.